



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2022 оны 05 сарын 03 өдөр

Дугаар А/625

Арвайхээр

**Боловсрол, шинжлэх ухааны газрын дүрэм,
бүтэц, орон тооны дээд хязгаар
батлах тухай**

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, Засгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн “Аймгийн Засаг даргын Тамгын газрын бүтэц, орон тооны хязгаар тогтоох тухай” 377 дугаар тогтоол, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн “Журам шинэчлэн батлах тухай” А/61 дүгээр тушаал, 2022 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн “Аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газар, нийслэлийн Боловсролын газар, дүүргийн боловсролын хэлтсийн орон тооны жишиг батлах тухай” А/125 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн Засаг даргын дэргэдэх “Боловсрол, шинжлэх ухааны газрын дүрэм”-ийг 1 дүгээр, “Бүтэц, орон тооны дээд хязгаар”-ыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Тус дүрмийг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Боловсрол, шинжлэх ухааны газар (Н.Чимэддорж-Ойдов)-т, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс (Б.Сайнжаргал)-т тус тус үүрэг болгосугай.

3.Энэхүү дүрэм, бүтэц, орон тооны дээд хязгаар батлагдсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2016 оны 09 дүгээр сарын 19-ний өдрийн “Боловсрол, соёл, урлагийн газрын дүрэм, бүтэц орон тооны дээд хязгаар батлах тухай” а/424, 2019 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн “Захирамжид нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” А/299 дүгээр захирамжуудыг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

6222 11 0483

D:My Doc. Zahiramj. Zasag darga

Аймгийн Засаг даргын 2022 оны 05 дугаар
сарын 05-ны өдрийн 1125 дугаар
захирамжийн 1 дүгээр
хавсралт

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ГАЗРЫН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.Аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газар (цаашид “газар” гэх)-ын бүрэн эрх, чиг үүрэг хэрэгжүүлэхтэй холбогдох харилцааг энэхүү журмаар зохицуулна.

1.2.Газар нь үйл ажиллагаандаа Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, төрөөс боловсролын талаар баримтлах бодлого, Төрийн албаны тухай хууль, Боловсролын тухай багц хууль, Төрөөс шинжлэх ухааны талаар баримтлах бодлого, Боловсрол, шинжлэх ухааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан шийдвэр, холбогдох бусад хууль тогтоомж, Төсвийн тухай хууль, Төрийн албан ёсны хэлний тухай хууль, Шинжлэх ухаан, технологийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Авилгын эсрэг хууль, Шилэн дансны тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Засгийн газрын болон аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр болон тэдгээртэй нийцүүлж гаргасан бусад хууль тогтоомжийг мөрдлөг болгоно.

1.3.Газар нь хүний эрхийг дээдэлсэн, хүн бүрд тэгш хүртээмжтэй, тэгш боломжийг олгосон чанартай боловсролын үйлчилгээ үзүүлэх, багш ажилтны мэргэжлийн тасралтгүй хөгжлийг дэмжих, хүний насан туршдаа суралцахуйг дэмжих. чадахуйн зарчимд суурилсан удирдлага, зохион байгуулалтыг хэрэгжүүлэх. цахим боловсрол, сургалтын уян хатан хэлбэрийг дэмжих. үр дүн, гүйцэтгэлд суурилах. хувь хүний эрх, хэрэгцээ шаардлагад нийцсэн, нээлттэй, уян хатан, тасралтгүй, сургалтын арга зүй, технологи хөгжүүлэхэд чиглэсэн. шийдвэр гаргахад олон нийтийн оролцоо, хамтын ажиллагааг хангасан байх зарчмыг үйл ажиллагаандаа баримтална.

Хоёр. Үйл ажиллагааны үндсэн чиглэл

2.1.Холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг орон нутгийн хэмжээнд зохион байгуулах чиглэлээр:

2.1.1.Салбарын хөгжлийн бодлого, хууль тогтоомж, шийдвэрийг байгууллага, олон нийтэд сурталчлан таниулах, хэрэгжилтийг зохион байгуулах, тэдгээрийг цэцэрлэг, сургууль, мэргэжлийн боловсролын байгууллагад хэрэгжүүлэхэд мэргэжил, арга зүй, удирдлагын дэмжлэг үзүүлэх, зөвлөн туслах, тайлагнах.

2.1.2.Боловсрол, шинжлэх ухааны салбарт хүчин төгөлдөр мөрдөж байгаа хууль тогтоомжийн мэдээллийн сан бүрдүүлж байгууллагын цахим хуудаст байршуулах, баяжилт шинэчлэл хийх, хэвийн ажиллагааг хангах.

2.1.3.Шинээр батлагдсан эрх зүйн баримт бичиг, хууль тогтоомжийн хэрэгжилт болон цаг үеийн бусад асуудлаар цэцэрлэг, сургууль, мэргэжлийн боловсрол (цаашид “боловсролын сургалтын байгууллага” гэх)-ын байгууллагын удирдах ажилтанд мэдээлэл өгөх, санал солилцох (уулзалт, цахим хурал, сургалт/семинар, хэлэлцүүлэг гэх мэт) үйл ажиллагааг тогтмол хэрэгжүүлэх.

2.1.4.Боловсролын салбарыг хөгжүүлэх орон нутгийн бодлого, арга хэмжээ, төлөвлөгөө, нийтлэг зохицуулалтын асуудлаар аймгийн Засаг даргын дэргэдэх Шинжлэх

ухаан, технологийн орон нутаг дахь салбар зөвлөлийн шийдвэр, зөвлөмж гаргахад мэргэжил, арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, шийдвэр, зөвлөмжийн хэрэгжилтийг зохион байгуулах, үр дүн, гүйцэтгэлийг тайлагнах.

2.1.5.Боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөр, үнэлгээ, арга зүй, технологи, суралцагчийн эрх, хамгаалал, хөгжил, төлөвшил, тэгш хамран сургалт, ажил мэргэжлийн чиг баримжаа, багш, ажилтны мэргэжлийн тасралтгүй хөгжил, цахим шилжилт, сургууль, цэцэрлэгийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд багш, удирдах ажилтныг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, зөвлөн туслах, суралцагч, эцэг, эх, асран хамгаалагч, олон нийтийг энэ чиглэлийн мэдээллээр хангах, дэмжлэг үзүүлж ажиллах, холбогдох талуудын түншлэлийн үйл ажиллагааны хэрэгжилтийн явц, үр дүнгийн талаар Боловсролын ерөнхий газар болон боловсролын үнэлгээ, эрдэм шинжилгээ, арга зүйн байгууллагыг мэдээллээр хангах, санал боловсруулах.

2.1.6.Боловсролын тухай хууль, Бага, дунд боловсролын тухай хуульд заасан сургалтын байгууллагын өөрийн болон мэргэжил, арга зүйн удирдлага, багшийн ёс зүйн зөвлөлийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд мэргэжлийн зөвлөгөө, арга зүйн удирдамжаар хангах, багш, ажилтан ёс зүйн хэм хэмжээний зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэхэд чиглэсэн соён гэгээрүүлэх арга хэмжээ зохион байгуулах, холбогдох мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллах.

2.1.7.Сургалтын үйл ажиллагаанд хөтлөх сургалтын баримт бичиг /сурагчийн хувийн хэрэг, ангийн журнал/ болон багш, сурагчийн сурах бичиг, сургалтын хэрэглэгдэхүүнээр хангах ажлыг зохион байгуулах, сургуулиудад арга зүйн дэмжлэг үзүүлэх, зөвлөн туслах, тайлагнах.

2.1.8.Бага, дунд боловсролын тухай хуульд заасан боловсролын баримт бичиг (гэрчилгээ, үнэмлэх) олгохтой холбогдох асуудлын хэрэгжилтийг зохион байгуулах, удирдлага зохицуулалтаар хангах, хяналт тавих, тайлагнах.

2.1.9.Ерөнхий боловсролын сургуулийн орчин дахь хүүхэд хамгааллын бодлого, сургуулийн орчны аюулгүй байдлын болон дотуур байрын орчин, үйлчилгээний стандартын хэрэгжилт, хүүхдийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээ, хоол тэжээл, хүнсний норм, норматив, аюулгүй байдалд мэргэжлийн байгууллага, олон нийт, эцэг эх, асран хамгаалагчийн тавих хяналтыг тогтмолжуулж, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хүүхдийг хүчирхийлэл, гэмт хэрэг, хорт зуршил, авто замын болон болзошгүй эрсдэлд өртөхөөс сэргийлэх, нийгмийн сөрөг үзэгдлээс хамгаалах үйл ажиллагааг нэгдсэн бодлого, арга зүйн удирдамж, зохицуулалтаар хангах.

2.1.10.Боловсролын чанар, гүйцэтгэлийн үнэлгээний тогтолцоог хөгжүүлэх ажлыг хэрэгжүүлэх, сургалтын байгууллагын үнэлгээний чанар, үр дүн болон багшийн ажлын гүйцэтгэлийг хөндлөнгөөс үнэлэх, үйлчилгээний чанар үр дүнг сайжруулах.

2.1.11.Үр дүн, гүйцэтгэлд суурилсан төсвийн шинэчлэл, сайжруулалтын тогтолцоог хэрэгжүүлэх.

2.1.12.Боловсролын цахим шилжилт, гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлийн үед хичээл, сургалтыг тасралтгүй үргэлжлүүлэх нөхцөл боломжийг бүрдүүлэх, бэлэн байдлыг хангахад арга зүйн удирдлагаар хангах, дэмжлэг үзүүлэх.

2.1.13.Орон нутгийн боловсролын сургалтын байгууллагын орчинд хүүхэдтэй зүй бус харилцах хандлага гаргахгүй байх, өсвөр үеийнхнийг дарамт, дээрэлхэлт, хүүхэд, залуучууд гэмт хэрэг, зөрчил, хорт зуршилд /цахим орчин, согтуурах, мансуурах, донтох байдалд/ өртөхгүй байх болон хүүхдийн нийгэм, сэтгэл зүйн судалгаанд суурилсан нөлөөллийн арга хэмжээг холбогдох байгууллагатай хамтран тогтмол зохион байгуулах.

2.1.14.Орон нутгийн цэцэрлэг, сургуулийн насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн илрүүлэг хийх, холбогдох байгууллагатай хамтран оношлох, статистик цуглуулж,

Боловсролын удирдлага, мэдээллийн системд бүртгүүлэх, хэл, соёлын ялгаатай хүүхдийн цэцэрлэг, сургуульд хамрагдалт, суралцахуйн явц, үр дүнгийн талаар судалгаа хийж, сурлагын хоцрогдол нөхөх, тэгш хамруулах, холбогдох сургалт, нөлөөллийн үйл ажиллагаа, арга хэмжээ зохион байгуулах.

2.1.15.Орон нутгийн мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагын сургалтын чиглэл, хөтөлбөрийг орон нутгийн хөдөлмөрийн зах зээлийн эрэлттэй нийцүүлэн тодорхойлоход орон нутгийн төрийн байгууллага, ажил олгогч, мэргэжлийн салбар зөвлөлтэй хамтран боловсруулахад арга зүйн дэмжлэг үзүүлэх, түншлэлийг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, чиглүүлэх, төгсөгчийн хөдөлмөр эрхлэхэд орон нутгийн хөдөлмөрийн асуудал эрхэлсэн байгууллагатай хамтран ажиллах.

2.2.Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг байгуулах тусгай зөвшөөрөл олгох эсэх талаар дүгнэлт гаргаж, аймгийн Засаг даргад санал болгох чиглэлээр:

2.2.1.Боловсролын сургалтын байгууллага үүсгэн байгуулах, өөрчлөх асуудлаар магадлан шинжилгээ хийх шинжээчийн хэсгийг Боловсролын тухай хуульд заасны дагуу томилон ажиллуулж мэргэжлийн дүгнэлт гаргах.

2.2.2.Сургалт эрхлэх тусгай зөвшөөрөл олгох эсэх асуудлаар энэ журмын 2.2.1-т дурдсан шинжээчийн хэсгийн дүгнэлтийг аймгийн Засаг даргад хүргүүлэх.

2.2.3.Боловсролын тухай хуульд заасан байгууллагаас ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг үүсгэн байгуулсан шийдвэрийг үндэслэн тусгай зөвшөөрөлд хамаарах асуудлаар бүртгэл мэдээллийн сан үүсгэх, баяжилт хийх, тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагын биелэлтэд хяналт тавих, гарсан зөрчлийг арилгуулах арга хэмжээ авах.

2.2.4.Эрх бүхий байгууллагын шийдвэрээр сургалтын байгууллага татан буугдах, эсхүл тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох тохиолдолд тухайн байгууллагын албан хэрэг хөтлөлтийн явцад үүссэн хувь хүнд хамаарах архивын баримт /ажилд томилох, чөлөөлөх шийдвэр, төгсөгчид олгосон боловсролын баримт бичгийн бүртгэл зэрэг/-ыг хүлээн авч архивын байгууллагад шилжүүлэх.

2.3.Боловсролын сургалтын байгууллагын багш, ажилтнуудын хөдөлмөрийг бодитой үнэлж, шагнаж урамшуулах, нийгмийн баталгааг сайжруулахад дэмжлэг үзүүлэх чиглэлээр:

2.3.1.Боловсролын сургалтын байгууллагын болон хүний нөөцийн менежментийг сайжруулах, боловсролын чанартай үйлчилгээ үзүүлэхэд өмчийн бүх хэлбэрийн цэцэрлэг, сургууль, мэргэжлийн боловсролын байгууллагуудыг нэгдсэн бодлого, мэргэжлийн удирдлагаар хангах, зөвлөн туслах.

2.3.2.Өмчийн бүх хэлбэрийн сургууль, цэцэрлэгийн багш, ажилтны мэргэжлийн тасралтгүй хөгжлийг дэмжих, арга зүйн хөгжилд дэмжлэг үзүүлэх, багш, сурагчдын дунд эрх бүхий байгууллагаас зөвшөөрсөн олимпиад, уралдаан тэмцээнийг зохион байгуулах, үр дүнг тайлагнах.

2.3.3.Багш нарын мэргэжлийн бүлгийг байгуулж, багш, ажилтан харилцан туршлага солилцох, бүтээлч үйл ажиллагаа, тэргүүн туршлагыг хөгжүүлэх, тэдний шилдэг арга зүй, технологийг боловсролын технологийн санд бүртгэж нийтийн хүртээл болгох.

2.3.4.Боловсролын чанарын баталгаа, хүүхэд бүрийг хөгжүүлэх онол, арга зүйгээр багш, ажилтныг хангах, энэ чиглэлээр тэдний мэдлэг, ур чадварыг тасралтгүй хөгжүүлэх, сургалтын шинэ технологи, арга зүй бүтээх, тохирц нийцлийг тогтоох, нутагшуулах, нэвтрүүлэх ажлыг цэцэрлэг, сургууль, багш нартай хамтран зохион байгуулах, үр дүнг түгээн дэлгэрүүлэх.

2.3.5.Боловсролын сургалтын байгууллагын орчинд суралцагчийн эрхийг хангах, хамгаалах, хөгжил төлөвшил, авьяасыг хөгжүүлэх, нийгэм-сэтгэл хөдлөлийн чадварыг хөгжүүлэх, чөлөөт цагийг үр дүнтэй өнгөрүүлэх, оролцоог хангах чиглэлээр секц,

дугуйлан, клубийн үйл ажиллагааг идэвхжүүлэх, тэдний өөрөө удирдах байгууллагаар дамжуулж, багаар ажиллах, хамтран суралцах арга зүйд суралцахад арга зүйн дэмжлэг үзүүлэх, хүүхдийн болон мэргэжлийн бусад байгууллагатай хамтран ажиллах, багш, ажилтныг арга зүйн удирдлагаар хангах, дэмжлэг үзүүлэх.

2.3.6.Сургуулийн өмнөх, ерөнхий боловсрол, мэргэжлийн боловсролын насны хүүхэд, залуусыг боловсролын үйлчилгээнд тэгш хамран сургах боломжийг нэмэгдүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх, үр дүнг хянаж, дүгнэх.

2.3.7.Багш, ажилтны ажлын гүйцэтгэл, ур чадварыг үнэлэх ажлыг Боловсролын үнэлгээний төвтэй хамтран зохион байгуулах, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, зөвлөгөө өгөх, тайлагнах.

2.3.8.Орон нутаг болон боловсролын сургалтын байгууллагын түвшинд үнэлгээний чиглэлээр хүний нөөцийг бэлтгэх, мэргэжил дээшлүүлэх, чадавхыг бэхжүүлэх сургалтыг зохион байгуулахад Боловсролын ерөнхий газартай хамтран ажиллах.

2.3.9.Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгт гүйцэтгэлийн үнэлгээг зохион байгуулахад энэ чиг үүрэг бүхий сургалтын менежер, арга зүйчдэд арга зүйн дэмжлэг үзүүлэх, үнэлгээний явцад хяналт тавих, гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнд үндэслэн орон нутгийн түвшинд багшийн мэргэжил дээшлүүлэх сургалтын хэрэгцээг тодорхойлох, багшийн болон байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэх, үр дүнг тооцох, хэрэгжилтэд хяналт тавих.

2.3.10.Багш, ажилтан, суралцагчийн бүтээлч үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах, урамшуулан дэмжих чиглэлээр төр, олон нийт, хувийн хэвшлийн байгууллагатай хамтран ажиллах, төрийн одон медаль, салбарын болон нутгийн захиргааны байгууллагын шагналд нэр дэвшүүлэх.

2.3.11.Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн багш, ажилтны нийгмийн асуудлаар судалгаа хийх, Төрийн албаны тухай хуулийн холбогдох заалтад заасны дагуу нийгмийн баталгааг хангуулах санал боловсруулах, санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх ажлыг зохион байгуулах.

2.3.12.Багш, ажилтнуудыг ажлын байранд нь хөгжүүлэх, менторыг ажиллуулах, мэргэжлийн бүлэг нөхөрлөлийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх.

2.3.13.Сургалтын байгууллагуудын сүлжээ үүсгэн багш, ажилтан харилцан туршлага солилцох, бүтээлч үйл ажиллагаа, тэргүүн туршлагыг хөгжүүлэх, түгээн дэлгэрүүлэх, тэдний шилдэг арга зүй, технологийг боловсролын технологийн санд бүртгэж, нийтийн хүртээл болгох.

2.3.14.Хүүхдийн хөгжил төлөвшил, авьяасыг хөгжүүлэх, чөлөөт цагийг үр дүнтэй өнгөрүүлэх чиглэлээр хүүхдийн болон мэргэжлийн бусад байгууллагатай хамтран ажиллах, багш, ажилтныг арга зүйн удирдлагаар хангах, дэмжлэг үзүүлэх.

2.3.15.Сургуулийн гадна байгаа хүүхэд болон иргэдийн насан туршдаа тэгш хүртээмжтэй суралцах боломжийг бүрдүүлэх, боловсрол нөхөн олгох үйлчилгээ үзүүлэх ажлыг Насан туршийн боловсролын нэгжтэй хамтран зохион байгуулах, арга зүйн удирдлагаар хангах, дэмжлэг үзүүлэх.

2.3.16.Боловсролын сургалтын байгууллагын хүний нөөц, боловсон хүчний бодлогын хэрэгжилтийг хангаж ажиллах.

2.3.17.Орон нутгийн боловсролын сургалтын байгууллагын албан хаагчдын ажлын гүйцэтгэл, ур чадварыг үнэлэх асуудлаар сургууль, цэцэрлэг, мэргэжлийн боловсролын байгууллагад мэргэжил, арга зүйн удирдамж, зөвлөгөө өгөх.

2.4.Боловсролын байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавих, үнэлэх чиглэлээр:

2.4.1.Өмчийн бүх хэлбэрийн сургалтын байгууллагын үйл ажиллагаанд тогтмол хяналт тавих, зөвлөн туслах, дэмжлэг үзүүлэх.

2.4.2.Сургууль, цэцэрлэг, мэргэжлийн боловсролын байгууллагыг аттестатчилах ажлыг боловсрол, шинжлэх ухааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан журам болон аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргаас өгөгдсөн үүрэг чиглэлийн дагуу Боловсролын үнэлгээний төвтэй хамтран зохион байгуулах, дүнг холбогдох байгууллагад танилцуулах, шаардлагатай арга хэмжээг зохион байгуулах.

2.4.3.Боловсрол, шинжлэх ухааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас хийх боловсролын чанарын үндэсний үнэлгээг орон нутагт зохион байгуулах, тэдгээрийн үр дүнгийн мөрөөр шаардлагатай арга хэмжээ авч хэрэгжүүлэх.

2.4.4.Сургууль, цэцэрлэг, мэргэжлийн боловсролын байгууллагын үйл ажиллагааны чанар, үр дүнг үнэлэх, хяналт- шинжилгээ хийх ажлыг олон нийт, иргэний нийгмийн байгууллагын оролцоотой зохион байгуулах, зөвлөн, туслах.

2.4.5.Иргэдийн насан туршийн суралцахууд дэмжлэг үзүүлэх, суралцах боломжийг нэмэгдүүлэх, үйлчилгээний чанар, хүртээмж, үр нөлөөг тандах судалгаа, оношилгоо, хэрэглэгчийн үнэлгээний ажлыг багш, ажилтан, иргэд, олон нийтийн оролцоотой зохион байгуулах, үр дүнг мэдээлэх, үр дүнд суурилан үйл ажиллагаа төлөвлөх, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах.

2.4.6.Орон нутгийн боловсролын сургалтын байгууллагын хөгжил, үйлчилгээний чанар, хүртээмж, үр нөлөөг тандах судалгаа, шинжилгээ, хэрэглэгчийн үнэлгээний ажлыг багш, ажилтан, иргэд, олон нийтийн оролцоотой зохион байгуулах, үр дүнг мэдээлэх.

2.4.7.Сургууль, цэцэрлэг, боловсролын сургалтын байгууллага, багшийн үйл ажиллагаанд өөрийн үнэлгээ, дотоод хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцоо төлөвшүүлэх ажлыг арга зүйн удирдамжаар хангаж зөвлөн туслах, хамтран ажиллах.

2.4.8.Орон нутагт элсэлтийн ерөнхий шалгалт, их, дээд сургуульд оюутан элсүүлэх ажлыг холбогдох мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулах, үр дүнд шинжилгээ хийх.

2.4.9.Боловсролын үйлчилгээний хүртээмж, чанар, үр ашгийн үзүүлэлтүүдийг тооцох, сайжруулах хариу арга хэмжээ авах.

2.4.10.Орон нутгийн хэмжээнд мэдээллийн системийн ашиглалт, үйл ажиллагаанд хяналт тавьж, мэдээллийн үнэн зөв, шуурхай байдлыг ханган, мэдээллийн сан бүрдүүлэх, түүнийг шийдвэр гаргалтад ашиглах, мэдээллийн сангийн баяжуулалт, хэрэглэгчдийн чадавхыг сайжруулахад дэмжлэг үзүүлэн ажиллах.

2.4.11.Хичээл сургалтын үйл ажиллагааг цахимаар зохион байгуулахад удирдлагаар хангах, эрсдэлийг тооцох, хэрэгжилтэд хяналт тавих, цахим сургуулийн сургалтын үйл ажиллагааг дэмжих, багш, суралцагчийг чиглүүлэх, дэмжин туслах, ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сонгон судлах хичээл сонголт, хуваарилалтыг хийхэд болон сургалтын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэн хэрэгжилтийг ханган ажиллах, сургуулиудад цахим технологид суурилсан шалгалтыг зохион байгуулах сургалтын орчныг бий болгоход дэмжлэг үзүүлэх.

2.4.12.Салбарын хөрөнгө оруулалтын хэрэгцээ шаардлага, хэрэгжилтийн явцын мэдээлэл нэгтгэх, хяналт тавих, сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын салбарын цахим төсвийн системийг удирдах, орон нутгийн боловсролын сургалтын байгууллагыг мэргэжил арга зүйгээр хангах, боловсролын сургалтын байгууллагуудын батлагдсан төсвийн санхүүжилтийг зохион байгуулах, удирдах, хянах, төрийн сангийн үйл ажиллагаанд хамтран оролцох, орон нутгийн байгууллагуудын төсвийн гүйцэтгэлийг хянах, судалгаа тооцоо хийх, нэгтгэх.

2.5.Боловсролын тайлан, мэдээ, мэдээллийг хууль тогтоомжид заасан журмын дагуу холбогдох байгууллагад тайлагнах, гаргаж өгөх чиглэлээр:

2.5.1.Хууль, Улсын Их Хурлын тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын шийдвэр, арга хэмжээ, төлөвлөгөө, гэрээ, конвенц, бусад холбогдох баримт бичгийн хэрэгжилтийн явц, үр дүн болон байгууллагын тухайн жилийн үйл ажиллагааны тайланг хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнгийн хамт холбогдох байгууллагад тогтоосон хугацаанд тайлагнах, мэдээлэл хүргүүлэх.

2.5.2.Дээд шатны байгууллагаас сургууль, цэцэрлэг, мэргэжлийн боловсролын байгууллагад хамаарах цаг үеийн үйл ажиллагаа, зарим шийдвэрийн хэрэгжилтийн талаар шаардсан мэдээ, мэдээллийг шуурхай гаргаж хүргүүлэх, эргэх холбоотой ажиллах.

2.5.3.Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсрол, мэргэжлийн боловсрол, сургалтын статистикийн мэдээлэл цуглуулах, нэгтгэн боловсруулах, дүн шинжилгээ хийх, мэдээллийн сан бүрдүүлэх, мэдээллээр үйлчлэх.

2.5.4.Цэцэрлэг, сургуульд хамрагдах хүүхдийн ойрын болон хэтийн төлвийн таамаглал боловсруулах, бусад шаардлагатай тооцоо, судалгаа хийх.

2.5.5.Тайлан, мэдээ, мэдээллийг судалгаа, баримт нотолгоонд тулгуурлан үнэн зөв, чанартай боловсруулах, орон нутгийн боловсролын асуудлаар Боловсрол, шинжлэх ухааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагыг мэдээллээр хангах.

2.6.Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн хамран сургах тойрог тогтоох чиглэлээр:

2.6.1.Орон нутгийн хөгжлийн бодлого, төлөвлөлт, бүс нутгийн онцлог, хүн амын нягтрал, хэтийн төлөв, цэцэрлэг, сургуулийн барилгын хүчин чадал, нөөцийг харгалзан цэцэрлэг, сургуулийн хамран сургах тойрог тогтоох, хэрэгжүүлэх ажлыг арга зүйн удирдамж, зохицуулалтаар хангах, хяналт тавих.

2.6.2.Газарзүйн мэдээллийн системийн орон зайн дүн шинжилгээнд тулгуурлан сургууль, цэцэрлэгийн барилгыг шинээр барих, өргөтгөх хэрэгцээ, шаардлагыг элсэлтийн болон хүн амын өсөлтийн байдал, шилжилт, хөдөлгөөний чиг хандлага, нутаг орны хөгжлийн төлөвлөлт зэрэг олон талын хүчин зүйлсийг харгалзан тодорхойлох ажлыг мэргэжлийн удирдлагаар хангах, судалгааны үндсэн дээр орон нутгийн өмчийн цэцэрлэг, сургуулийн байршил, бүтэц, хэв шинжийг оновчтой тогтоох, өөрчлөн байгуулах, цэцэрлэг, сургуулийн ачааллын тэнцвэрт байдлыг хангах, дахин төлөвлөлт хийх, арга хэмжээ авах.

2.6.3.Боловсролын сургалтын байгууллагын барилга байгууламж, нөөц хэрэглэгдэхүүн, цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсролын байгууллагад хамрагдаж буй суралцагч, багш, ажилтны шилжилт хөдөлгөөн, өөрчлөлтийн мэдээлэл тогтмол цуглуулж судалгаа хийх, хариу арга хэмжээ төлөвлөх, хэрэгжүүлэх, энэ чиглэлээр холбогдох байгууллагыг мэдээллээр хангах.

2.6.4.Цэцэрлэг, сургуулийн хамран сургах тойргийн хүүхдийн боловсролын үйлчилгээнд хамрагдалтад шинжилгээ хийх, үйлчилгээний гадна хоцорсон хүүхдэд чиглэсэн хариу арга хэмжээ авах ажлыг холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулах.

2.7.Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн захирал, эрхлэгчийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулах чиглэлээр:

2.7.1.Сургууль, цэцэрлэгийн захирал, эрхлэгчийн албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалтыг Төрийн албаны зөвлөлөөс баталсан журамд заасны дагуу зохион байгуулах, үр дүнг ил тод, нээлттэй мэдээлэх.

2.7.2.Удирдах албан тушаалд томилогдох ажилтны албан тушаалын тодорхойлолт боловсруулах, баталгаажуулахад томилох эрх бүхий этгээдэд мэргэжлийн дэмжлэг

үзүүлэх.

2.8.Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдыг дүрэмт хувцсаар бүрэн хангах чиглэлээр:

2.8.1.Өмчийн бүх хэлбэрийн сургуулийн сурагчийн дүрэмт хувцасны хангалтын байдал, загвар, хийц, чанарын асуудлаар хэрэглэгчийн сэтгэл ханамжийг судлах, сургуулиудаас мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх.

2.8.2.Батлагдсан шаардлага, загварын дүрэмт хувцсаар сурагчийг хангах ажлыг өмчийн бүх хэлбэрийн сургуулиудад хэрэгжүүлэхэд арга зүйн дэмжлэг үзүүлэх, хяналт тавих, үр дүнг мэдээлэх.

2.9.Шинжлэх ухаан, технологи, инновацийн хууль тогтоомж, дүрэм журмын хэрэгжилтийг орон нутагт зохион байгуулах, удирдлага, зохицуулалтаар хангах чиглэлээр.

2.9.1.Аймгийн Засаг даргын дэргэд "Шинжлэх ухаан, технологийн орон нутаг дахь салбар зөвлөл"-ийг байгуулж, үйл ажиллагааны төлөвлөгөөг газрын төлөвлөгөөтэй уялдуулах, шинжлэх ухаан, технологи, инновацийн үйл ажиллагааны тасралтгүй, тогтвортой байдлыг хангах, хэрэгжүүлэх.

2.9.2.Шинжлэх ухаан, технологи, үндэсний инновацийг хөгжүүлэх орон нутгийн бодлого, арга хэмжээ, төлөвлөгөө, нийтлэг зохицуулалтын асуудлаар аймгийн Засаг дарга болон Засаг даргын дэргэдэх Шинжлэх ухаан, технологийн орон нутаг дахь салбар зөвлөл шийдвэр, зөвлөмж гаргахад мэргэжил, арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, шийдвэр, зөвлөмжийн хэрэгжилтийг зохион байгуулах, үр дүн, гүйцэтгэлийг тайлагнах.

2.9.3.Орон нутагт шинжлэх ухаан, технологи, инновацийн дэд бүтэц байгуулах, хөгжүүлэх асуудлаар хууль тогтоомжид заасан чиг үүргийг хэрэгжүүлэх, холбогдох байгууллагатай хамтран ажиллах.

2.9.4.Шинжлэх ухаан, технологи, инновацийн дэд бүтцийг хөгжүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг орон нутгийн жил бүрийн төсөвт тусган санхүүжүүлж, хэрэгжилтийг ханган ажиллах.

2.9.5.Орон нутгийн байгалийн болон бусад нөөцөд тулгуурласан, шинжлэх ухаан, технологийн үр дүнд суурилсан бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлэх, хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулалт, зохицуулалтыг ханган ажиллах.


2.9.6.Орон нутгийн иргэдийн санал санаачилгыг үйлдвэрлэлд нэвтрүүлэх, гарааны бизнес эрхлэх, хөгжүүлэхэд чиглэсэн сургалт зохион байгуулах.

2.9.7.Орон нутгаас төрөн гарсан эрдэмтэн, судлаачидтай хамтран ажиллах, орон нутгийн шийдвэрлэх асуудалд шинжлэх ухааны зүгээс үнэлэлт дүгнэлт өгөх, судалгаа, шинжилгээнд татан оролцуулах чиглэлээр хамтран ажиллах.

2.9.8.Орон нутагт сургалт-эрдэм шинжилгээ-үйлдвэрлэлийн цогцолбор байгуулах хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, хамтран ажиллах, их, дээд сургуулийн үйл ажиллагааг орон нутгийн ажил олгогч, аж ахуйн нэгж, байгууллагатай холбох, суралцагчдад дадлага хийх боломжийг бүрдүүлэх, сургуулийн өмнөх, ерөнхий боловсрол, мэргэжлийн боловсролын сургалтын байгууллага болон ажил олгогч, шинжлэх ухааны байгууллагын хамтын ажиллагаа, уялдааг хангах, түншлэлийг бий болгох, бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэх.

2.9.9.Аймаг, орон нутагт тулгамдсан асуудлыг шийдвэрлэх чиглэлээр эрдэм шинжилгээний байгууллага, техникийн болон мэргэжлийн боловсролын сургалтын байгууллага, их, дээд сургуулиудтай хамтран ажиллах.

2.9.10.Аймаг, орон нутгийн онцлогт тулгуурлан байгаль, нийгмийн шинжлэх ухааны танин мэдэхүйн контентыг бүтээж, орон нутгийн болон үндэсний олон нийтийн радио телевиз, хэвлэл мэдээллийн хэрэгслээр түгээн дэлгэрүүлэх арга хэмжээг зохион



байгуулах.

2.10.Газар нь энэ журмын 2.1-2.9-д заасан үйл ажиллагааны чиглэлээр:

2.10.1.Боловсрол, шинжлэх ухааны сайдын аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээнд заасан ажлын хэрэгжилтийг орон нутгийн хэмжээнд хангана.

2.10.2.Боловсролын удирдлагын мэдээллийн нэгдсэн систем (багш, ажилтан, суралцагч, боловсролын сургалтын байгууллага, түүний орчны мэдээллийн бүртгэл бүхий)-ийг бүрдүүлж, хөгжүүлэхэд цэцэрлэг, сургууль, мэргэжлийн боловсролын байгууллагад мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх, зөвлөн тусална.

2.10.3.Боловсролын сургалтын байгууллагын мэдээлэл, холбооны дэд бүтэц, сүлжээний төхөөрөмж, шилэн кабелийн ашиглалт үйлчилгээний хэвийн ажиллагааг хангах, утасгүй дотоод сүлжээний болон цахим сургалтын орчныг бүрдүүлэх, тогтвортой байдлыг хангах, хүний нөөцийг чадавхжуулахад дэмжлэг үзүүлнэ.

2.10.4.Боловсрол, шинжлэх ухааны байгууллагын ажилтан авлига авах, ашиг сонирхлын зөрчилд өртөхөөс урьдчилан сэргийлэх зорилгоор Авлигын эсрэг хуулийн 5, 6 дугаар зүйл, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсэгт заасан үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

2.10.5.Орон нутгийн боловсролын сургалтын байгууллагын гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх, хууль тогтоомжид нийцсэн төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, гадаадын ижил төстэй байгууллагатай хамтран ажиллах, харилцан туршлага солилцох боломжийг бүрдүүлнэ.

Гурав. Удирдлага, зохион байгуулалт

3.1.Газар нь энэхүү дүрэмд заасан бүрэн эрх, мэргэжил, арга зүйн удирдлагыг хэрэгжүүлэх чиглэлээр.

3.1.1.Дүрэмд заасан бүрэн эрх, мэргэжил, арга зүйн удирдлагыг хэрэгжүүлэх нөхцөлийг хангасан зохион байгуулалтын бүтцийн нэгжтэй байна. Зохион байгуулалтын бүтэц, орон тооны дээд хязгаарыг аймгийн Засаг дарга батална.

3.1.2.Газарт эрх бүхий байгууллагаас баталсан орон тооны хязгаарт багтсан газрын дарга, хэлтсийн дарга, ахлах мэргэжилтэн, мэргэжилтэн, үйлчилгээний ажилтан ажиллана.

3.1.3.Газрын дарга, мэргэжилтэн нь батлагдсан албан тушаалын тодорхойлолтод заасан тусгай шаардлага болон ажилтанд мэргэжлийн зөвлөгөө, арга зүйн мэргэшсэн үйлчилгээ үзүүлэх, судалгаа хийх, мэдээлэл боловсруулах болон багаар ажиллах ур чадвартай байх бөгөөд харилцааны соёл, ёс зүйн хэм хэмжээ сахин ажиллана.

3.1.4.Газрын сургуулийн өмнөх, ерөнхий боловсролын асуудал хариуцсан мэргэжилтэн нь хүүхдийн эрх, хөгжил, хамгаалал, боловсролын сургалтын байгууллагын болон хүний нөөцийн тасралтгүй хөгжлийг хангах, боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөр хэрэгжүүлэх, чанарын болон гүйцэтгэлийн үнэлгээ зохион байгуулах, сургалтын арга зүй, технологи, цахим сургалт хөгжүүлэх, сургалтын цахим агуулга, контент боловсруулахад багш, удирдах ажилтанд мэргэжил, арга зүйн мэргэшсэн үйлчилгээ үзүүлэх, багшийн мэргэжлийн тасралтгүй хөгжлийг хангах, боловсролын судалгаа хийх, мэдээлэл боловсруулах зэрэг асуудлыг хэрэгжүүлнэ.

3.1.5.Газрын дарга нь холбогдох хууль тогтоомжид заасны дагуу байгууллагын дарга төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх чиг үүргийн хэрэгжилтийг ханган ажиллана.

3.1.6.Газар нь дэргэдээ боловсролын чанарыг дээшлүүлэхэд багш, удирдах ажилтан, судлаач, иргэд, төрийн болон төрийн бус байгууллагын оролцоог нэмэгдүүлэх

зорилгоор мэргэжлийн өндөр зэрэгтэй багш, удирдах ажилтны төлөөлөл бүхий орон тооны бус “Арга зүйн зөвлөл” ажиллуулж болно.

3.1.7.Газар нь эрдэм шинжилгээ-судалгаа, инноваци, арга зүйн төв, түшиц цэцэрлэг, сургуультай байж болно. Түшиц цэцэрлэг, сургууль нь лаборатори цэцэрлэг, сургууль байна.

3.1.8.Боловсролын салбарт хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаа, үр дүн, хүний нөөц, төсөв, санхүүгийн болон хуулиар хориглосноос бусад мэдээллийг байгууллагын цахим хуудас, мэдээллийн самбарт байршуулах замаар байгууллагын ил тод нээлттэй байдлыг хангана.

3.1.9.Ном гарын авлага, сэтгүүл бусад зүйл худалдан авахыг багш, ажилтанд тулган шаардах байдалд хяналт тавина.


3.1.10.Газар нь харьяа орон нутгийн боловсролын сургалтын байгууллагуудыг санхүүгийн удирдлагаар хангаж, төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлд хяналт тавьж, санхүүгийн мэдээ, тайланг нэгтгэн үнэлэлт дүгнэлт өгч ажиллана.

3.1.11.Боловсролын салбарын барилгыг шинээр барих, засварлах, материаллаг бааз, хөгжим, техник хэрэгсэл, ном, тоног төхөөрөмжөөр хангах ажлыг Боловсрол, шинжлэх ухааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, орон нутгийн удирдлага, холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулна.

3.1.12.Боловсрол, шинжлэх ухааны үйл ажиллагааг олон нийтийн оролцоо, түншлэлд тулгуурлан шударга, хүртээмжтэй, ил тод, нээлттэй, тэгш байдлыг ханган явуулна.

3.1.13.Аймгийн хэмжээний боловсролын байгууллагын уралдаан тэмцээн, олимпиадыг зохион байгуулах, арга зүй удирдлагаар хангах, зохион байгуулалттай холбогдон гарах зардлыг газрын жил бүрийн төсөв болон бусад эх үүсвэрээс бүрдүүлэн санхүүжүүлнэ.

Аймгийн Засаг даргын 2022 оны... дугаар
сарын ...-ны өдрийн... дугаар
захирамжийн... дугаар
хавсралт



АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ
УХААНЫ ГАЗРЫН БҮТЭЦ, ОРОН ТООНЫ ДЭЭД ХЯЗГААР

Боловсрол, шинжлэх ухааны газар		Орон тоо
Боловсрол, шинжлэх ухааны газрын дарга		1
Захиргаа, удирдлага, судалгааны хэлтэс		
1.	Хэлтсийн дарга (Сургалт эрхлэх тусгай зөвшөөрөл, хүний нөөцийн бодлого, аймгийн ёс зүйн зөвлөлийн нарийн бичиг, гадаад харилцаа, хамтын ажиллагаа, боловсролын салбарын урсгал төсвийн төлөвлөлт, зохицуулалт, хөрөнгө оруулалт, эдийн засгийн үр ашгийн шинжилгээ судалгаа)	1
2.	Бодлого төлөвлөлт, хяналт-шинжилгээ үнэлгээ хариуцсан ахлах мэргэжилтэн (Өргөдөл, гомдол, дотоод ажил, гүйцэтгэлийн үнэлгээ, АТГ-ын ЭБАТ)	1
3.	Боловсрол, шинжлэх ухааны салбарын төсвийн төлөвлөлт, зохицуулалт хариуцсан ахлах мэргэжилтэн	1
4.	Салбарын хөрөнгө оруулалт, төсвийн гүйцэтгэл хариуцсан мэргэжилтэн	1
5.	Шинжлэх ухаан, технологи, инноваци, судалгаа, шинжилгээ, мэргэжлийн боловсрол, статистик мэдээлэл, цахим технологи хариуцсан мэргэжилтэн (байгууллагын мэдээллийн технологи, мэдээллийн сүлжээ, газрын дэргэдэх Багш хөгжлийн төв хариуцах)	1
6.	Хүүхдийн эрх, хөгжил, хамгаалал, нийгмийн ажилтан, сургалтын орчин хариуцсан мэргэжилтэн (Тэгш хамран сургалт)	1
7.	Хоол үйлдвэрлэл, үйлчилгээ, хүнсний аюулгүй байдал, эрүүл ахуй хариуцсан мэргэжилтэн	1
8.	Нягтлан бодогч	1
9.	Архив, бичиг хэргийн ажилтан	1
10.	Нярав	1
11.	Жолооч	1
Сургалт, арга зүйн хэлтэс		
12.	Хэлтсийн дарга (Сургалтын бодлого, багшийн мэргэжлийн хөгжил, арга зүй, насан туршийн боловсрол, гүйцэтгэлийн үнэлгээ)	1
13.	Сургуулийн өмнөх боловсрол хариуцсан ахлах мэргэжилтэн	1
14.	Бага боловсрол хариуцсан ахлах мэргэжилтэн	1
15.	Монгол хэл, бичиг, уран зохиолын боловсрол хариуцсан мэргэжилтэн	1
16.	Математикийн боловсрол хариуцсан мэргэжилтэн (гүйцэтгэлийн үнэлгээ)	1
17.	Физик, мэдээллийн технологийн боловсрол хариуцсан мэргэжилтэн	1
18.	Гадаад хэлний боловсрол хариуцсан мэргэжилтэн (сургалтын орчин)	1

19.	Биеийн тамирын боловсрол хариуцсан мэргэжилтэн (боловсролын бичиг баримт олгох асуудал хариуцах)	1
20.	Дүрслэх урлаг, зураг зүй, технологийн боловсрол хариуцсан мэргэжилтэн (сонгон, секц, дугуйлангийн үйл ажиллагаа, дүрэмт хувцас)	1
21.	Нийгмийн ухаан (түүх, газар зүй, нийгэм судлал, иргэний ёс зүйн боловсрол)-ны боловсрол хариуцсан мэргэжилтэн	1
22.	Хими, биологи, эрүүл мэндийн боловсрол хариуцсан мэргэжилтэн	1
23.	Хөгжмийн боловсрол хариуцсан мэргэжилтэн (сурах бичиг, хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах)	1
Батлагдсан орон тоо		24

-oOo-